



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/07

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр хотын дулаан түгээх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, хэрэглэгчдийн шугам сүлжээний ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Хяналт шалгалтын ажлыг сайтар зохион байгуулж, дүгнэлтийг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0011

Аймгийн Засаг даргын 2023 оны
01 дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Г.Дэлгэрмандах (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга)

О.Төмөрчөдөр (Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Тайванбаатар (Харилцаа холбоо, хэмжил зүйн хяналтын улсын байцаагч)

С.Мөнх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

С.Цэдэнсодном (Арвайхээр хотын Захирагчийн албаны ерөнхий менежер)

Д.Цэцэгмаа (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь орон тооны гишүүн)

Б.Даваадавга ("Онги-Ус суваг" ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер)

Нарийн бичгийн дарга: Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)